



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/161/СТА-ТШЗ

Баянхонгор 2020 он	Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576    Цахим хаяг: <a href="mailto:munkhbatb@audit.gov.mn">munkhbatb@audit.gov.mn</a> Аудитын менежер: А.Цээням Утас: 88089024    Цахим хаяг: <a href="mailto:tseenyama@audit.gov.mn">tseenyama@audit.gov.mn</a> Аудитор: Ж.Өсөхбаяр Утас: 99890393    Цахим хаяг: <a href="mailto:usuhuu83@yahoo.com">usuhuu83@yahoo.com</a> Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

1. Аудитын гэрчилгээ .....	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.13. Шилэн дансны мэдээлэл .....	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал.....	10
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	13
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	15
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	15

1. Аудитын гэрчилгээ



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ШҮҮХИЙН ШИЙДВЭР  
ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН ДАРГА  
О.ХАДБААТАР ТАНАА

2020.02.05 № 1/15  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод

C:\Users\audit\_bhr3\Downloads\БНА-2020-161-СТА-ТШЗ-Гэрчилгээ.docx

• 005020006

хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б МӨНХБАТ

## 2. Аудитын тайлан

### 2.1. Оршил

Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга О.Хадбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 28-наас 2020 оны 02 дугаар сарын 03-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 1/19 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Шүүхийн шийдвэрийг нэг мөр гүйцэтгэж, цагдан хорих, баривчлах болон хорих ял эдлүүлэх үйл ажиллагааг олон улсын жишгийн түвшинд хуулийн хүрээнд зохион байгуулах, эд хөрөнгийн холбогдолтой шийдвэр бүрийн биелэлтийг хангах, үйлчлүүлэгч, хэрэглэгчид шуурхай үйлчлэхэд оршино".

Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Алба хаагчдын сахилга бат, үүрэг хариуцлагыг дээшлүүлж, ажлын бүтээмжийг дээшлүүлэх,
- Шийдвэр гүйцэтгэх тасгийн бодит биелэлтийг ахиулах, хүүхдийн тэтгэлгийн гүйцэтгэх баримт бичиг тус бүрд хийгдэх шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эрчимжүүлэх, хуримтлагдсан төлбөрийг эрс бууруулах,
- Санхүүгийн сахилга батыг сайжруулж, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, шилэн дансны мэдээллийн ил тод байдлыг хангах,
- Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган, алба хаагчдыг ажлын байранд мэргэшүүлэх, сургалтын чанар, үр дүнг дээшлүүлэх, ажиллах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх,

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Ординат" ХХК-ийн "Unicus" программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай

илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 35 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 669077.9 мянган төгрөгөөс тооцон 13381.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 13385.2 мянган төгрөгөөр тооцсон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 27156.3 мянган төгрөгөөр буюу 1.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дансны код	Балансын үзүүлэлт	/мянган төгрөг/		
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>47780.46</b>	<b>53557.61</b>	<b>5777.15</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00	0.00
33	АВЛАГА	0.00	0.00	0.00
34	УРЬДЧИЛГАА	0.00	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	47780.46	53557.61	5777.15
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1338677.86	1305744.41	-32933.45
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1386458.32</b>	<b>1359302.01</b>	<b>-27156.30</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00	0.00
51	Засгийн газрын хувь оролцоо	1386458.32	1359302.01	-27156.30
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1386458.32</b>	<b>1359302.01</b>	<b>-27156.30</b>

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь 2019 онд төсвийн 6000.0 мянган төгрөгийн хөрөнгөөр бэлтгэсэн гадна хашааг орлогод авах тухай Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэр гараагүйгээс дуусаагүй үйлдвэрлэл дансанд эргэлтийн хөрөнгөөр бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд өмнөх онуудад худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 820.0 мянга, үнэ төлбөргүй 40442.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн ч тайлант онд 74195.8 мянган төгрөгийн элэгдэл нэмж хуримтлуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1359302.0 мянган төгрөг болж 27156.3 мянган төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан үр дүн 27156.3 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

**2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь тайлант онд 725.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 408.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 56.3 хувиар биелүүлсэн байна.

*Хүснэгт 2. Төсөвт байгууллагын өөрийн орлого*

*/мянган төгрөг/*

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Туслах үйл ажиллагааны орлогоор	725.0	408.0	317.0	56.3
<b>Нийт дүн</b>	725.0	408.0	317.0	56.3

Төсөвт байгууллагын өөрийн орлого 317.0 мянган төгрөгөөр тасарсан нь туслах аж ахуйн үйл ажиллагааг тайланд онд явуулаагүйгээс орлого тасарч харин түрээсийн орлогоор 264.0 мянга, эргэлт уулзалтын орлогоор 45.0 мянга, тендерийн баримт бичгийн орлогоор 99.0 мянган төгрөгийн орлого орсон байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 597476.4 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 596751.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 725.0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Тайлант онд улсын төсвөөс авах 596751.4 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авсан ч туслах үйл ажиллагааны орлогоос орох 725.0 мянган төгрөгөөс 408.0 мянган төгрөг төвлөрүүлсэн нь тайлант онд туслах аж ахуйн үйл ажиллагаа буюу блок үйлдвэрлэх үйл ажиллагааг явуулаагүйтэй холбоотой байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөлттэй харьцуулан авч үзэхэд тайлант онд туслах аж ахуйн үйл ажиллагаа явуулаагүйтэй холбоотой байр ашиглалттай холбоотой тогтмол зардал төлөвлөснөөс 435.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 596428.2 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь улсын төсвөөс 596751.4 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагааны зарцуулж 731.2 мянган төгрөг хэмнэгдэн төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

**Нэмэлт төсөв:** Нэмэлт төсвийн дансаар тайлант онд гүйлгээ хийгдээгүй байна.

**2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 35 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 26 эрсдэл тодорхойлж нийт 26 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 693.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 508.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 84.8 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 100.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 184.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 84.8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Хүнсний материал бэлтгэн нийлүүлэгч “Далай ээж” ХХК-иас нэг төрлийн бүтээгдэхүүнийг гэрээнд заасан үнээс 500 төгрөгөөр илүү үнээр худалдан авч нийт 72000 төгрөг илүү зарцуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь "бараа, ажил,

үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй, Далай ээж Баянхонгор ХХК-тай 2019.01.30-ны өдөр байгуулсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын мах, махан бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэхээр захиалагч нийлүүлэгчийн хооронд байгуулсан ШШГГ-2019/01 тоот гэрээний Багц 2 -т заасан тедерийн үнийг зөрчсөн, "Хэмжилт", гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

2. 2019 оны 07 дугаар сард ажиллаагүй алба хаагчийн цалинг Нийгмийн даатгалын байгууллагад 320.0 мянган төгрөгөөр мэдээлж төсвөөс 12800 төгрөг төлсөн нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх;" гэсэн заалттай нийцэхгүй, "Хэмжилт", гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

Аудитаар илэрсэн 100.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 133 мэдээллийг хугацаанд нь, 16 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	8	1	2
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	4		
4	Сар бүр	3	36	36		
5	Тухай бүр	8	96	81	15	
	Нийт	27	151	133	16	2

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

"Зөрчилгүй" дүгнэлт

Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн еөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 1. Зардлын данстай холбоотой асуудал

- 1.1. **Илрүүлэлт:** Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлаас 2019 оны 04 сард Номгон ариусгал ХХК-ийн ариутгалын төлбөр 100.0 мянган төгрөгийг шилжүүлж, зориулалт бусаар зарцуулсан байна.
- 1.2. **Эрсдэл:** Зардлын бүлэг хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэл үүссэн.
- 1.3. **Өгсөн зөвлөмж:** Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулж, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ыг хэрэгжүүлж ажиллах
- 1.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Цаашид алдааг давтан гаргахгүй зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>47780458.10</b>	<b>53557605.88</b>
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	47780458.10	53557605.88
351	Түүхий эд материал	9549873.00	9549873.00
35110	Тусгай зориулалттай материал	9381923.00	9381923.00
35130	Эм боох материал	167950.00	167950.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	0.00	6000000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	343520.00	0.00
354	<b>Хангамжийн материал</b>	37887065.10	38007732.88
35410	Бичиг хэргийн материал	1799300.00	1704150.00
35420	Аж ахуйн материал	18613611.00	20580986.00
35430	Сэлбэг хэрэгсэл	545700.00	93000.00
35440	Түлш, шатах тослох материал	1875000.00	750000.00
35460	Хүнсний материал	1895741.10	456630.88
35470	Бусад хангамжийн материал	13157713.00	14422966.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1338677858.87</b>	<b>1305744407.56</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1338677858.87	1305744407.56
392	<b>Биет хөрөнгө</b>	1219161987.59	1187568840.90
39201	Барилга, байгууламж, орон сууц	1121586711.54	1121586711.54
39202	Хуримтлагдсан элэгдэл	51983921.29	90136640.84
39203	Авто-тээврийн хэрэгсэл	116980392.00	147813725.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	68891503.17	83224846.67
39205	Машины тоног төхөөрөмж (компьютер)	85641255.65	92079255.65
39206	Хуримтлагдсан элэгдэл	47501423.19	59011394.10
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	78004356.00	81995356.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	19459027.95	28318473.68
39211	Батлан хамгаалах, иргийн зориулалттай тоног төхөөрөмж	4715148.00	4715148.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	70000.00	70000.00
393	<b>Биет бус хөрөнгө</b>	119515871.28	118175566.66
39301	Програм хангамж	6417692.31	6417692.31
39302	Хуримтлагдсан элэгдэл	4723221.03	6063525.65
39303	Бусад биет бус хөрөнгө	117821400.00	117821400.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1386458316.97</b>	<b>1359302013.44</b>
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1386458316.97</b>	<b>1359302013.44</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1386458316.97	1359302013.44
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	221624669.45	221624669.45
51101	Өмч: - төрийн	221624669.45	221624669.45
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	733803537.05	706647233.52
51210	Өмнөх үеийн үр дүн	733803537.05	733803537.05
51220	Тайланг үеийн үр дүн	0.00	-27156303.53
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	431030110.47	431030110.47
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1386458316.97</b>	<b>1359302013.44</b>

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>544679379.68</b>	<b>642106308.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>6703379.68</b>	<b>45354908.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	6703379.68	45354908.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6703379.68	45354908.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	716975.68	408000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5986404.00	44946908.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>537976000.00</b>	<b>596751400.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	537976000.00	596751400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	537976000.00	596751400.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>585887494.87</b>	<b>669262611.53</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>585887494.87</b>	<b>669262611.53</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>583287463.91</b>	<b>667371447.84</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	339859080.26	407305329.25
210101	Үндсэн цалин	228193380.26	276211503.21
210102	Нэмэгдэл	108165800.00	125835885.04
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1999900.00	2183480.00
210104	Урамшуулал	1500000.00	3074461.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6948265.84	8937593.30
210201	Тэтгэврийн даатгал	0.00	613854.38
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	66666.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	66666.57
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	14814.78
210205	Эрүүл мэндийн даатгал	6948265.84	8175591.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83326669.00	85860077.17
210301	Гэрэл, цахилгаан	10556743.00	11821752.17
210302	Түлш, халаалт	64603926.00	65421333.00
210303	Цэвэр, бохир ус	8166000.00	8616992.00
2104	Хангамж, бараа материалын зардал	36949944.72	25232384.07
210401	Бичиг хэрэг	4122940.00	2615410.00
210402	Тээвэр, шатахуун	20789960.00	15945000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3494445.62	2836721.07
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	760000.00	258000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3215539.50	3369753.00
210408	Бараа материал акталсны зардал	4567059.60	207500.00
2105	Нормативт зардал	30494730.10	48016110.22
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1369200.00	1360000.00
210502	Хоол, хүнс	29125530.10	46656110.22
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9562900.00	7876870.00
210604	Урсгал засвар	9562900.00	7876870.00
2107	Томилолт, зочны зардал	2477500.00	1746000.00
210702	Дотоод албан томилолт	2477500.00	1746000.00

**Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6983304.00	6550159.52
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5024380.00	4108050.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300000.00	300000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	404320.00	740512.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55000.00	77000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1098560.00	1167597.52
210807	Газрын төлбөр	101044.00	157000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	66685069.99	75846924.31
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	799600.00	1041200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1632300.00	609950.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	64253169.99	74195774.31
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	2600030.96	1891163.69
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	288000.00	160000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	288000.00	160000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1000000.00	1000000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1000000.00	1000000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1312030.96	731163.69
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1312030.96	731163.69
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-41208115.19</b>	<b>-27156303.53</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-41208115.19</b>	<b>-27156303.53</b>

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>538675469.54</b>	<b>597159400.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>715000.50</b>	<b>408000.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	715000.50	408000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	715000.50	408000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	715000.50	408000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>537960469.04</b>	<b>596751400.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	536663969.04	596751400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	536663969.04	596751400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1296500.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1296500.00	0.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>538675469.54</b>	<b>596339400.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>538675469.54</b>	<b>596339400.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>537387469.54</b>	<b>594448236.31</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	339859080.26	407394222.55
210101	Үндсэн цалин	228193380.26	262965010.93
210102	Нэмэгдэл	108165800.00	140751211.62
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1999900.00	2178000.00
210104	Урамшуулал	1500000.00	1500000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6946290.66	8848700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6946290.66	8848700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83081269.00	85860077.17
210301	Гэрэл, цахилгаан	10556743.00	11821752.17
210302	Түлш, халаалт	64358526.00	65421333.00
210303	Цэвэр, бохир ус	8166000.00	8616992.00

**Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>33454925.62</b>	<b>22576677.07</b>
210401	Бичиг хэрэг	3725850.00	2519760.00
210402	Тээвэр, шатахуун	21138000.00	14820000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3494445.62	2836721.07
210405	Хог хаягдал зайлуулах, хоргон мэрэгчдийн устгал, ариутгал	760000.00	258000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4336630.00	2142196.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>31559860.00</b>	<b>46122000.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4360000.00	1360000.00
210502	Хоол, хүнс	27199860.00	44762000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>29642100.00</b>	<b>13699250.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	9688500.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	800000.00	320000.00
210604	Урсгал засвар	19153600.00	13379250.00
<b>2107</b>	<b>Томилголт, зочны зардал</b>	<b>2477500.00</b>	<b>1746000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2477500.00	1746000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>7660344.00</b>	<b>6550159.52</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5201380.00	4108050.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300000.00	300000.00
210803	Даатгалын үйлчилгээ	424100.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	404320.00	740512.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55000.00	77000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1174500.00	1167597.52
210807	Газрын төлбөр	101044.00	157000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2706100.00</b>	<b>1651150.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	799600.00	1041200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1906500.00	609950.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1288000.00</b>	<b>1891163.69</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>288000.00</b>	<b>160000.00</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	288000.00	160000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1000000.00</b>	<b>1000000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1000000.00	1000000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>731163.69</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		731163.69
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>0.00</b>	<b>820000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>0.00</b>	<b>820000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>820000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>0.00</b>	<b>820000.00</b>
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/		820000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>0.00</b>	<b>-820000.00</b>

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	103,803,269.45	215,516,741.65	720,854,138.29	1,040,174,149.39
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	117,821,400.00	0.00	130,452.65	117,951,852.65
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	221,624,669.45	215,516,741.65	720,984,590.94	1,158,126,002.04
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	215,513,368.82	0.00	215,513,368.82
C07	Тайлант үеийн үр дүн			12,818,946.11	12,818,946.11
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	221,624,669.45	431,030,110.47	733,803,537.05	1,386,458,316.97
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	221,624,669.45	646,543,479.29	746,622,483.16	1,386,458,316.97
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	221,624,669.45	431,030,110.47	733,803,537.05	1,386,458,316.97
D08	Тайлант үеийн үр дүн			-27,156,303.53	-27,156,303.53
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	221,624,669.45	431,030,110.47	706,647,233.52	1,359,302,013.44

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Баглагдсан төлөвлөгө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	597476400.00	596428236.31	1048163.69	99.8
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	597476400.00	596428236.31	1048163.69	99.8
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	596265200.00	595268236.31	996963.69	99.8
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	407557600.00	407394222.55	163377.45	100.0
210101	Үндсэн цалин	262983700.00	262965010.93	18689.07	100.0
210102	Нэмэгдэл	140895900.00	140751211.62	144688.38	99.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2178000.00	2178000.00	0.00	100.0
210104	Урамшуулал	1500000.00	1500000.00	0.00	100.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	8848700.00	8848700.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	8848700.00	8848700.00	0.00	100.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	86295100.00	85860077.17	435022.83	99.5
210301	Гэрэл, цахилгаан	12165000.00	11821752.17	343247.83	97.2
210302	Түлш, халаалт	65437600.00	65421333.00	16267.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	8692500.00	8616992.00	75508.00	99.1
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	22577600.00	22576677.07	922.93	100.0
210401	Бичиг хэрэг	2506400.00	2519760.00	-13360.00	100.5
210402	Тээвэр, шатахуун	14820000.00	14820000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интэрнэтийн төлбөр	2778800.00	2836721.07	-57921.07	102.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	274400.00	258000.00	16400.00	94.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2198000.00	2142196.00	55804.00	97.5
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	46122000.00	46122000.00	0.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1360000.00	1360000.00	0.00	100.0
210502	Хоол, хүнс	44762000.00	44762000.00	0.00	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	14700100.00	14519250.00	180850.00	98.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	6000000.00	820000.00	5180000.00	13.7
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	320000.00	320000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	8380100.00	13379250.00	-4999150.00	159.7
<b>2107</b>	<b>Томилголт, зочны зардал</b>	1750000.00	1746000.00	4000.00	99.8
210702	Догоод албан томилолт	1750000.00	1746000.00	4000.00	99.8
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6604100.00	6550159.52	53940.48	99.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4150000.00	4108050.00	41950.00	99.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300000.00	300000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	742100.00	740512.00	1588.00	99.8
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	80000.00	77000.00	3000.00	96.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1175000.00	1167597.52	7402.48	99.4
210807	Газрын төлбөр	157000.00	157000.00	0.00	100.0

**Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1810000.00	1651150.00	158850.00	91.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1200000.00	1041200.00	158800.00	86.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	610000.00	609950.00	50.00	100.0
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1211200.00	1160000.00	51200.00	95.8
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	211200.00	160000.00	51200.00	75.8
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	211200.00	160000.00	51200.00	75.8
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1000000.00	1000000.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1000000.00	1000000.00	0.00	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	597476400.00	596428236.31	1048163.69	99.8
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	596751400.00	596020236.31	731163.69	99.9
131001	Улсын төсвөөс санхүүжих	596751400.00	596020236.31	731163.69	99.9
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	725000.00	408000.00	317000.00	56.3
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	725000.00	408000.00	317000.00	56.3
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	34	34	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	33	33	-	100.0
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	34	34	-	100.0
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	34	34	-	100.0

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР:

Ж.ӨСӨХБАЯР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЭНЯМ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

